

**БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН НЭГДҮГЭЭР
ХЭЛТСИЙН 2019 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРАЛД ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2019 оны 03 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Тус хэлтэс нь 2019 онд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас дэвшүүлсэн зорилт, хүрэх түвшингийн шалгуур үзүүлэлтийг хангах, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлын үр нөлөөг сайжруулах, алба хаагчдын шуурхай байдал, ажлын хариуцлага, сахилга бат, харилцааны соёлыг дээшлүүлэх, иргэдийн амгалан тайван ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийг чирэгдүүлэхгүй түргэн шуурхай үйлчлэх, албаны бэлэн байдал, мэргэжлийн ур чадвараа сайжруулахад онцгой анхаарч Монгол Улсын Үндсэн хууль, Цагдаагийн албаны тухай хууль, бусад хууль, тушаал, заавруудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан.

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын чиглэлээр
зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар**

1.1 Төлөвлөлт, зохион байгуулалтын чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал, Засгийн газраас гаргасан Цагдаагийн байгууллагатай холбоотой үүрэг, даалгавар, шийдвэрүүдийг тасаг, хэсгийн дарга, ахлах нарт болон бие бүрэлдэхүүнд тухай бүрт нь хүргэж, шаардлагатай тохиолдолд үүрэг, даалгавар шийдвэрийн талаар хэлэлцүүлэг, яриаг зохион байгуулан Цагдаагийн байгууллагад холбогдох үндэсний хөтөлбөрийн 1, удирдах дээд байгууллагаас өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрүүдийн 1, биелэлт тооцох баримт бичгийн жагсаалтын 1 хавтсыг тусгайлан гаргаж, бүртгэлийг хөтөлсөн. Хөтөлбөр, эрх зүйн актуудын биелэлтийг тооцон Нийслэлийн цагдаагийн газарт файлаар болон цаасаар хүргүүлсэн.

Хэлтсийн даргын зөвлөл 2019 оны 1 дүгээр улиралд 5 удаа хуралдаж, үйл ажиллагааны чиглэлээр 5, хүний нөөцийн чиглэлээр 18, алба хаагчдын сахилга хариуцлагын талаар 6, нийт 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу албан тушаал дэвшүүлэх нөөцөд 30 алба хаагч, албан тушаал дэвшүүлэх, өөрчлөх саналтай 2, цагдаагийн албанаас чөлөөлүүлэх 1, төрийн дээд боон одон медалиар шагнуулах 3, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнуулахаар 4 алба хаагчийн, хүүхэд асрах чөлөө хүссэн 2, Бүгд Найрамдах Солонгос улс руу зорчих виз хүсэхээр тодорхойлолт гаргуулах 2, сул орон тоонд томилуулах саналтай 3, цол сэргээх болон хугацааны цолоор шагнуулах 6, 2 нийт 55 материалыг Нийслэлийн цагдаагийн газрын холбогдох хэлтэст хүргүүлсэн. Тус хэлтсийн даргын А тушаал 9, Б тушаал 25 дугаар өгч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, Дэд дарга, Нийслэлийн цагдаагийн газрын дарга нарын өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, албан даалгаврын заалт бүрийн ард уг ажлыг хариуцан хэрэгжүүлэх албан тушаалтны нэр, цолыг бичиж, нэгдсэн байдлаар биелэлт үр дүнг нь тооцох албан тушаалтанд цохолт хийж эзэнжүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан. Тухайлбал: Цагдаагийн ерөнхий газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, Цагдаагийн ерөнхий газрын даргын удирдах ажилтны сургалт зөвлөгөөний үеэр өгсөн үүрэг, цагдаагийн

байгууллагад хамаарах хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган батлуулан холбогдох алба нэгжүүдэд хүргүүлсэн.

Тус хэлтсийн архивын өрөөнд урсгал засвар хийж, шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган дотоод нөөц бололцоог ашиглан архивын баримтын тавиурыг шинэчилсэн. Мөн 229 килограмм устгалтын баримтыг устгаж, байнга хадгалах баримтуудыг цахим хэлбэрт оруулж, түр хадгалах, 70 жил хадгалах баримтуудын хавтсыг сольж сэргээн засалт хийж, эмхлэн ажилласан. Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн 2018 оны архивын баримт бичгийг журмын дагуу хүлээн авч, шаардлага хангаагүй баримтыг буцаан дахин цэгцлүүлэн баримтаа татсан. Тус хэлтсийн хэмжээнд архивт байгаа баримт бичгүүдэд хэсэгчилсэн тооллого хийхэд 164 боть байнгын баримт байгаа ба 2014 оноос хойшхи баримтад тооллого хийж байна.

Тус хэлтсийн хэмжээнд удирдах дээд байгууллагаас 2019 оны эхний 3 сард 1214 албан бичгийг хүлээн авснаас хугацаатай 374 албан бичгийн холбогдох албан тушаалтнуудад хүлээлгэн өгч, хариуг хүргүүлэн ажилласан. Удирдах дээд байгууллага болон бусад газар хэлтэс рүү нийт 1725 албан бичгийг боловсруулан хүргүүлэн ажилласан.

Алба хаагчийн нийгмийг асуудлыг шийдвэрлэх зорилгоор дүүргийн 1 алба хаагчийг газар, гэртэй болгуулах саналыг дүүргийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамрагдах, болон амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой алба хаагчдын судалгааг гаргаж, Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн. Тус хэлтсийн өрх толгойлсон болон олон хүүхэдтэй 2 ажилтанд 1 удаагийн тусламж үзүүлсэн.

Алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор хэлтсийн төв байрны 1, 2, 3 дугаар давхарын коридорыг дотоод нөөц бололцоог ашиглан 1,500,000 төгрөгийн урсгал засварыг хийсэн. Алба хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор хурууны хээгээр бүртгэх цаг бүртгэлтийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Алба хаагчдын ажлын хэвийн нөхцөлийг хангах зорилгоор Нийслэлийн цагдаагийн газраас дүүрэг дэх хэлтсүүдэд хуваарилсан 200 ширхэг тусгай хэрэгсэлийг эргүүлийн жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдад олгосон. Мөн алба хаагчдад 850,000 төгрөгийн бичиг хэргийн материалыг олгосон.

Мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлын хүрээнд Цагдаагийн ерөнхий газраас Евростандарт лаборатриотой хамтран ажиллах удирдамж, хуваарь ирүүлсний дагуу алба хаагч, ажилтны элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 120 алба хаагч хамрагдсан ба хамраагдаагүй буюу ээлжийн амралттай, харуул, жижүүртэй шалтгаантай байсан алба хаагчдыг 03 дугаар сарын 14-ний өдөр шинжилгээ өгүүлэх ажлыг зохион байгуулсан.

Тус хэлтсийн ажлын байрны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийн талаар мэргэжлийн хянатын газрын улсын байцаагчийн 2017 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 02-07-383/62 дугаартай “Барилгуудын ашиглалт төлөв байдлын тухай” дүгнэлт гаргуулсан ба уг дүгнэлтийн хугацаа дуусаагүй ба тус хэлтсийн эрүүлжүүлэх саатуулах байранд хортой нөхцөлд ажилладаг тул агаар чийгшүүлэгч аппарат 2 ширхэгийг авч байруулан ажиллуулж байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн мэдээллийг алба хаагчдад хүргэх зорилгоор “Эрдэнэс таван толгой” хувьцаат компаний үйл ажиллагаа, бодлого, зорилтын талаарх сургалт, мэдээллийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдөр алба хаагчиддаа зохион байгуулсан.

Алба хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, бэлтгэлжилтийн түвшинг нэмэгдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх дүүргийн 16 хороонд байрлах Өнөр бүл төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан долоо хоног бүрийн “Пүрэв” гарагт нийт алба хаагчдыг спортоор хичээллэх боломжийг хангасан.

Энэ онд сард бие бүрэлдэхүүний дундын сангаас алба хаагчдын нийгмийн асуудал, соён гэгээрүүлэх ажилд нийт 2,144,000 төгрөгийг тус тус зарцуулсан. Тасаг албад сар бүр хамт олны хурлыг зохион байгуулж, алба хаагчдынхаа ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн давхардсан тоогоор 61 алба хаагчийн албан тушаалын цалинг 5-25 хувь нэмж, 42 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувь бууруулж олгосон.

Тус хэлтсийн мөрдөн байцаах тасгаас санаачлан сарын ажлаараа тасаг хамт олноо хошуучлан ажилласан алба хаагчийг ажлын үр дүнгээр нь цалинг нэмэхийн зэрэгцээ тасгийн дотоод нөөц бололцоо /хуримтлал/-нд тулгуурлан урамшуулж байх зохион байгуулалтын арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн. Энэ ажлын хүрээнд тасгийн 1, 2 дугаар сарын ажлын тайланг хэлэлцэн эдгээр саруудад хамт олноо хошуучлан ажиллаж хамгийн олон хэрэг шийдвэрлэсэн мөрдөгчийг гэр бүлийн гишүүний хамт кино театруудад саяхан нээлтээ хийж шинээр гарч байгаа уран сайхны кино, “Шинэ үе” продакшны шинэ уран бүтээлийн тоглолтыг үзэх эрхийн бичиг, өөрийн хариуцсан баг хамт олноо сайн зохион байгуулж, хамгийн олон хэрэг яллагдагчаар татаж шийдвэрлэсэн багт ус цэвэршүүлэгч, бичгийн цаас, бичгийн хэрэглэл зэргээр урамшуулсан нь алба хаагчдын ажиллах урам зоригийг сэргээж, ажлын төлөө өрсөлдөх боломж нөхцөлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлсэн үр дүнтэй арга хэмжээ болсон.

Цагаан сарын баярын хүлээн авалт, хүндэтгэлийн арга хэмжээ, ахмадуудын гарын бэлгэнд нийт 2,170,000 төгрөг зарцуулсан.

Энэ оны эхний 3 сарын байдлаар алба хаагчийн аюулгүй байдалд халдсан, мэдээ, мэдээлэл бүртгэгдээгүй.

1.2. Хүний нөөцийн талаар

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, Цагдаагийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний холбогдох заалтыг хэрэгжүүлэх, алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, дадал чадвар эзэмшүүлэх, албаны соёл, хандлага, төлөвшил, сэтгэлгээг өөрчлөх, өөрөө сурч, хөгжих хандлагыг төлөвшүүлэх, хөгжүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, сургалтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор 2019 оны албаны сургалтын төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулсан. Албаны сургалтын календарчилсан төлөвлөгөөнд тусгагдсан мэдвэл зохих хууль тогтоомж, алба хаагчийг хөгжүүлэх, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах чиглэлээр 2019 оны эхний 3 сард 4 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 498 алба хаагчийг хамруулсан.

Хууль сахиулах их сургуулийн Ахисан шатны сургуулийн магистрын хөтөлбөрт 2 алба хаагчийг хамруулсан. Мөн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/28 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2019 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө”-нд тусгагдсан сургалтанд 13 алба хаагч, Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд 2019 оны 03 дугаар сард “Авлигын эсрэг нэг өдрийн хөтөлбөрт сургалт”-д 12 алба хаагч, Архивын ерөнхий газрын архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалтанд 2019 оны 02 дугаар сард 1 алба хаагч, Нийслэлийн цагдаагийн газраас Гамма мэргэжлийн гэрэл зургийн студитай хамтарсан гэрэл зургийн сургалтанд 2 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төвөөс зохион байгуулсан галт зэвсгийн сургагч

багш бэлтгэх сургалтанд 2019 оны 01 дүгээр сард 2 алба хаагч, Хүн худалдаалах гэмт эхрэгтэй тэмцэх чиглэлийн сургалтанд 2019 оны 03 дугаар сард 2 алба хаагчийг хамруулсан.

Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, тогтоомж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам болон бусад эрх зүйн актын талаарх мэдээллийг алба хаагчдад хүргэх 1 удаагийн сургалтанд 156 алба хаагчийг хамруулсан.

Тус хэлтсээс 1 алба хаагч Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дугаар Б/943 тушаалаар Филиппин улсын CELI сургуулийн англи хэлний бэлтгэлд 2019 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хугацаанд суралцсан. Хэлтсийн гадаад хэлний мэдлэгтэй алба хаагчдын судалгааг гаргаж НЦГ-т хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын НҮБ-ын энхийг сахиулах “UNMISS/UNMISS” ажиллагаанд үүрэг гүйцэтгэх Монгол Улсын Зэвсэгт хүчний 8 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнд орж үүрэг гүйцэтгэх цагдаагийн алба хаагчдын сонгон шалгаруулалтад оролцуулж, 1 алба хаагч Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар ажлаас чөлөөлөгдөн үүрэг гүйцэтгэж байна.

Тус хэлтсээс 2019 оны албаны сургалт соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг багтаасан каледарьчилсан төлөвлөгөөг гаргаж, мэдээллийн самбарт байрлуулсан.

Алба хаагчдын гэр бүлийн гишүүдтэйгээ чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, алба хаагчдын гэр бүлийн байдалтай танилцах, тэдний санал хүсэлтийг сонсох, тулгарч буй бэрхшээлийг тогтоох, алба хаагчдын ажлын ачаалал, стресс ядаргааг тайлах, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Соёл, соён гэгээрүүлэх ажил” /код 940/ -ын 940.2.1-д заасны дагуу нийт бие бүрэлдэхүүний дунд соёлын үйл ажиллагаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах зорилгоор 2019 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлэх төлөвлөгдсөн 6 соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан байна. Тухайлбал: Сар шинийн баярыг тохиолдуулан 62 ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардуулсан, алба хаагчдын дунд сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, эхний 3 байр шалгаруулж, үзэгчдийн дунд 3 онооны шидэлтийн тэмцээнийг зохион байгуулж, мөнгөн шагналаар шагнасан,

Тус хэлтсээс Нийслэлийн цагдаагийн газраас 2019 онд “Ахлах албан тушаалтнуудын жил” болгон уриалсантай холбогдуулан “Ахлахуудын зөвлөл”-ийг хэлтсийн даргын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулсан. Тус хэлтэст 2019 онд шинээр томилогдсон алба хаагч нарын сургагч-алба хаагчаар ахлах албан тушаалтнудаас томилж, шинээр томилогдсон алба хаагчийг ажил, албанд нь богино хугацаанд сургах, дасан зохицуулах, ажил мэргэжлийн алдаа дутагдал гаргуулахгүй байх, мэргэжлийн чиг баримжаатай болгох талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч сахилга, ёс зүйг төлөвшүүлж, ажиллах нөхцөлөөр хангаж, алба хаагч болон сургагч-алба хаагч нарын хооронд хамтран ажиллах гэрээ байгуулж, дадлагажуулан сургах үйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг үүрэг болгон ажилласнаар сахилгын арга хэмжээ авагдсан алба хаагч 2019 оны 1 дүгээр улиралд 6 алба хаагч сахилгын шийтгэл авагдсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буюу 66,6 хувиар буурсан байна.

Алба хаагчийн хувийн болон харилцааны соёлыг дээшлүүлэх, ажлын хариуцлага, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хамт олны эерэг уур амьсгалыг дээшлүүлэх, алба хаагчдын ажиллах урам зоригийг нэмэгдүүлэхээр “Ахлахуудын зөвлөл”-өөс санаачлан удирдлагуудын дэмжлэгтэйгээр цагдаагийн амаргүй бөгөөд хүндхэн алба

хааж буй ханыхаа түшиг тулгуур нь болсон эрхэмсэг гоо гэргий, хатан гоо ээжүүд нийт 159 гэр бүлийн гишүүдэд талархал илэрхийлсэн ил захидлыг сарнай цэцэг, дурсгалын зүйлийн хамт хүргүүлсэн ба гэр бүлийн гишүүдийн сэтгэлийг хөдөлгөсөн урам зориг өгсөн гэнэтийн сайхан арга хэмжээ болсон талаар гэр бүлийн гишүүд талархалаа илэрхийлсэн ба арга хэмжээг хэлтсийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс фэйсбүүк хуудас, <http://bayanzurkh-1.police.gov.mn/> цахим вэб хуудсанд мэдээллийг байршуулан сурталчилж ажилласан.

Алба хаагч, ажилтнуудын бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор тасаг, хэсгээс ямар уралдаан тэмцээн зохион байгуулах саналыг авч нэгтгэн хэлтсийн 2019 оны албаны сургалт, соён гэгээрүүлэх ажлын календарьчилсан төлөвлөгөөг хэлтсийн даргаар батлуулсан. 2019 оны нэгдүгээр улиралд Баянзүрхийн товчооноос Баянзүрх хайрхан хүртэл явган аялал, хэлтсийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж, 237 алба хаагч хамрагдсан.

Тус хэлтэс нь нийт 193 алба хаагч буюу 96 офицер, 87 ахлагч, 9 энгийн ажилтантай ажиллаж байгаагаас 1 орон тоо сул ажиллаж байна. хүний нөөцийн нөхөн хангалт 99,4 хувьтай байна. 2019 оны 1 дүгээр улиралд офицер 3, ахлагч 11 алба хаагч шинээр, 2 алба хаагч дэвшин томилогдсоноос 5 алба хаагч шилжин ирж, 2 алба хаагч чөлөөлөгдөж, 1 алба хаагч шилжин ажилласан байна.

Тус хэлтсээс 2018 онд ажлын үзүүлэлтээрээ А, В үнэлэгдсэн 2019 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгэгдэх хүсэлт гаргасан болон болзол шаардлагыг хангасан 30 алба хаагчийг нөөцөд оруулах боломжтой эсэхийг “Албан тушаал дэвшүүлэх /код-909/”-д заасны дагуу судлан шаардлага хангасан алба хаагчдыг албан тушаал дэвшүүлэх нөөцөд авах жагсаалтын дагуу холбогдох судалгааг гарган Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Алба хаагчдын 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд 94 алба хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг www.meduuleg.iaac.mn цахим хаягаар авч, мэдээллийг баталгаажуулан, номломжийг НЦГ-ын Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлж ажилласан. Хэлтсээс Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн төвд “Авлигын эсрэг нэг өдрийн хөтөлбөрт сургалт”-д 12 алба хаагчийг хамруулсан.

Иргэдэд ил тод нээлттэй үйлчлэх, цагдаагийн ажил үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор “Угтах үйлчилгээг”-г хэлтсийн хэмжээнд нэвтрүүлж, иргэдийг хэлтэс, тасгийн дарга нар хүлээн авч, уулзах хуваарийг гаргаж, хэлтсийн иргэдийн хүлээлгийн танхимд байрлах урсдаг самбар болон мэдээллийн самбарт байруулж, хуваарийн дагуу угтах үйлчилгээнд тасгийн дарга нар иргэдийг хүлээн авч санал хүсэлтийг сонсон ажилласан.

“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын хавсралтаар баталсан маягтын дагуу шилэн дансны цахим хуудсанд 42 мэдээ мэдээлэл, байгууллагын цахим хуудас <http://bayanzurkh-1.police.gov.mn/>-д 22 мэдээ мэдээлэл тус тус байршуулж, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллалаа.

Төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулахад санаачлагатай ажиллан бичгийн цаас, хувилагч, олшруулагч машины ашиглалтанд хяналт тавьж, байгууллагын холбоо, цахилгаан, усны үргүй зардлыг багасгах талаар анхаарч төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого барьж ажиллаж байна.

Алба хаагчийг албан тушаалд томилох, дэвшүүлэхдээ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Алба хаагчийг дэвшүүлэх” /код909/-ыг баримтлан нөөцийн

бүртгэлд орсон алба хаагчийг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн материалаа Нийслэлийн цагдаагийн газрын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

1.3 Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.

Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Засаг даргаас шийдвэрлүүлсэн хөрөнгө, зарцуулалт 2019 оны нэгдүгээр улиралд байхгүй байна.

Тус хэлтэс нь 2018 оны нэгдүгээр улиралд 659,9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 8,3 сая төгрөг төсөвт төвлөрүүлэн холбогдох гүйлгээнд хяналт тавьж, төсвийг зориулалтын дагуу зарцуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд цалингийн зардалд 575,2 сая төгрөг, НДШимтгэлд 12,1 сая төгрөг, тогтмол зардал болох Түлш халаалтын зардалд 6,3 сая төгрөг, гэрэл цахилгааны зардалд 8,0 сая төгрөг, цэвэр бохир усны зардалд 1,1 сая төгрөг, шатах тослох материалын зардалд 17,8 сая төгрөг, бичиг хэргийн зардалд 2,9 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 1,8 сая төгрөг, 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хоолны зардалд 1 хүнд 5,0 мянган төгрөг нийт 5,8 сая төгрөг, эмийн зардалд 75,0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардалд 354,9 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 500,1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,3 сая, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 2,2 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 635,6 сая төгрөгийн зардал гаргаж ажилласан.

Мөнгөн хөрөнгө, бараа материал, шатахууны тайлан, холбогдох журналуудыг тус бүрд нь хөтөлж, няраваар сар бүр тайланг гаргуулан, тулган шалгаж баталгаажуулсан. Мөн 95,2 сая төгрөгийн торгуулийн орлогыг орон нутгийн хүү торгуулийн дансанд төвлөрүүлсэн.

Эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн төлбөр төлөлтөнд хяналт тавьж, сар бүр тайланг хүлээн авч харилцахын хуулгатай тулган баталгаажуулж нийт 8,3 сая төгрөгийг байгууллагын 100200012005 тоот дансанд төвлөрүүлэн ажилласан.

Төсвийн орлого зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, 2019 оны төсвийн хуваарь, 2019 оны 1-3 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, 2019 оны 1-3 дугаар сарын 5 саяас дээш үнийн дүн бүхий орлого зарллагын гүйлгээ, жилийн төсөв нь 5 саяас дээш худалдан авалт буюу Петро стар ХХК-аас худалдан авсан шатахуун, Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ, ус сувгийн удирдах газарт тус тус шилжүүлсэн ашиглалтын зардал, Төгс дардас ХХК-аас худалдан авсан бичгийн цаасны зардлын дүн, 2019 оны үнэт цаасны орлогын төлөвлөгөө болон 1-3 дугаар сарын үнэт цаасны тайлан, Нийслэлийн цагдаагийн газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/12 тоот "Бараа материал актлах тухай" тушаал, хэлтсийн даргын 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн "Үндсэн хөрөнгө орлогод авах тухай" тушаал, 2018 оны жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан болон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт зэрэг мэдээ мэдээллийг <http://shilendans.gov.mn/> сайтад байршуулсан. Мөн иргэдийн хүлээлгийн танхимд байрлах мэдээллийн самбарт санхүүгийн мэдээллүүдийг тогтмол байршуулж хэвшсэн.

1.4 Сахилга, хариуцлага, дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын чиглэлээр

Тус хэлтсээс 2019 оны эхний 3 сарын байдлаар 4 офицер, 2 ахлагч бүрэлдэхүүнээс сахилгын шийтгэл авагдсан нь бие бүрэлдэхүүний 3,1 хувийг эзэлж байна. Үүнээс хэв

журмын офицер 1, хэсгийн байцаагч 1, жижүүрийн ахлах офицер 1, буса дофицер 1, хэв журмын цагдаа 2 байна. Гаргасан зөрчлийн хэлбэрээр нь авч үзвэл: цагдаагийн алба хаагчийг сахилгын дүрэм зөрчсөн 1, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм зөрчсөн 5 байна. Сахилга ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлөөр нь авч үзвэл: Хувь хүний буруутай үйл ажиллагаа 6 байна. Сахилгын шийтгэлийн төрлөөр нь авч үзвэл: албан тушаалын цалингийн хэмжээг 1 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах 4, цагдаагийн цол бууруулах 1, цагдаагийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах 1 шийтгэл оногдуулсан байна.

Сахилгын зөрчлийг тухайн байгууллагын дотоод хяналтаар 3, ёс журмын хяналтаар 1 зөрчил илэрч, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 1, тус хэлтсийн даргын тушаалаар 5 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Алба хаагчаас гаргаж буй сахилга ёс зүйн зөрчлийг тогтоох, шалтгаан, нөхцөлийг судлах зорилгоор сахилгын зөрчил бүрт албаны шалгалт явуулж, дүнг “Ёс зүйн зөвлөл”-өөр хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулж хэвшсэн.

Хууль зүйн сайдын 2017 оны “Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх тухай” 01 тоот албан даалгавар, ЦЕГ-ын даргын 2017 оны 01 тоот албан даалгавар, Засгийн газрын 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор алба хаагч нарт сургалт, мэдээлэл хийж, хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус газрын алба хаагчдаас сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн ажлын чиглэл, үүргийг хэрэгжүүлэх, зөрчихгүй байх талаар 12 заалт бүхий баталгааг 160 алба хаагчаас, бичгээр гаргуулан авсан. Алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр сахилгын хариуцлагын зөвлөгөөнийг шинэлэг байдлаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Тасгийн дарга, ахлах албан тушаалтнуудаас алба хаагчдад тавих хяналтыг болон хамтын ажиллагааг сайжруулахаар шинээр томилогдсон алба хаагчдын сургагч алба хаагчаар ахлах албан тушаалтнуудыг томилж, дадлагажуулах ажлыг зохион байгуулсан. Жижүүрийн бүрэлдэхүүнд гарч байгаа алба хаагчдыг согтуурал шалгах багажаар шалгаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулж, хариуцлагтай эргүүлийн илтгэх хуудсанд оруулж хэвшсэн ба одоогоор энэ төрлийн зөрчил дутагдал гараагүй. Хоногийн хугацаанд эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад иргэдтэй зөв боловсон харилцах, замын хөдөлгөөнд оролцохдоо Замын хөдөлгөөний дүрмийг хэрэгжүүлэх, дуудлага, мэдээлэлд очиж ажиллахдаа аюулгүй байдлаа хангах ажиллах чиглэлийн зааварчилгааг танилцуулж баталгаажуулж хэвшсэн.

Тус хэлтсийн албан тушаалтанд хандаж, иргэдээс 2019 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төв, “check my service аппликейшн”, “Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв”-д иргэдээс 4 талархал ирсэн ба гомдол, хүсэлт ирээгүй байна.

Байгуулага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах чиглэлээр мэдээллийн санд баяжилт хийж, ажилласан. Орон тооны бус ажлын хэсгийн ахлагчаас сар шинийн баяр, амралтын өдрүүдэд байгууллагын аюулгүй байдал, хэлтсийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 8 заалттай зааварчилгааг хүргүүлсэн.

Алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хуулийг нэг мөр хэрэглэх байдлыг сайжруулах зорилгоор Баянзүрх дүүргийн Прокурорын газартай хамтран хэргийн тооллого хийж, эрүүгийн хэрэг, гомдол мэдээллийн хяналтын бүртгэлийг MS Excel программ дээр шинэчлэн хийж, алба хаагч нэг бүрээр тулгалт хийж үлдэгдэл

хэргийн тоо, ажлын ачаалал зэргийг гарган энэхүү тооцоо судалгаан дээрээ үндэслэн хэргийн шийдвэрлэлтийг ахиулах, ажлын ачааллыг бууруулах зорилго тавин ажилласнаар тус хэлтсийн алба хаагчдаас прокурорын шаардлагад нэр заагдаагүй.

Цагдаагийн хэлтсийн эрсдэлийн үнэлгээг хэлтсийн даргын тушаалаар томилогдсон Эрсдэлийн үнэлгээ хийх орон тооны бус багаас хийж, эрсдэлийн санд баяжилт хийн, байгууллагын эрсдэлийг тооцон хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулсан. Цаашид эрсдэлүүдийг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцлага зохион байгуулж, гарсан санал, санаачлагыг нэгтгэн 2019 онд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээг авах төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус хэлтсээс тасаг, хэсгийн дарга нараас Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 246 дугаар тушаалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах /код-112”-ын дагуу алба хаагчдаас гаргасан сахилга, ёс зүйн зөрчилд албаны шалгалтыг тал бүрээс нь бүрэн гүйцэт, бодитой явуулж, алба хаагчийн гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоон, газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж хэвшсэн. Энэ онд тус хэлтсийн 12 алба хаагчдад холбогдуулан 9 албаны шалгалт явуулж, гаргасан зөрчлийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, эрх бүхий алба хаагчдаас дахин зөрчил, дутагдал гаргахгүй байх зорилгоор 10 алба хаагчдад зааварчилгаа өгч, хариуцсан алба хаагчдад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр тасгийн дарга нарт хугацаатай үүрэг хүргүүлж, биелэлтийг тооцон ажилласан.

Хоёр. Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

2.1. Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд:

Иргэд, байгууллага аж ахуйн нэгжээс цагдаагийн байгууллагад ирүүлсэн зөрчлийн шинжтэй 1995 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас, 341 зөрчлийн хэрэг үүсгэсэн, 762 зөрчлийн хэрэг үүсгэхээс татгалзах саналтай прокурорт хүргүүлж, хялбаршуулсан журмаар 110, харъяаллын дагуу 71 шилжүүлэн 1295 хэргийг шийдвэрлэж, 160 үлдэгдэл хэрэг, 711 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл хүлээн авч шалган шийдвэрлэж, гудамж, талбай, олон нийтийн газар болон ахуйн хүрээнд иргэдийн амгалан тайван байдал алдагдуулж, танхайрсан зөрчил гаргасан 1948 иргэн, 267 аж ахуй нэгж, байгууллагыг 95,700,000 төгрөгөөр, шүүхээр 86 хүнийг шүүхийн шүүгчийн захирамжаар 7-30 хоног баривчилж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдэд хууль, эрх зүйн талаар ухуулга, яриа таниулга, зөвлөгөө өгч ажилласан. Мөн 2018 онд нийт 17 гэмт хэрэг илрүүлж ажилласан.

Камер, техникийн хяналтын үйл ажиллагааны талаар

Телекамерийн 4 алба хаагч 2019 оны 03 дугаар сард давхардсан тоогоор 21 удаа 504 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1, 3 дугаар хэлтсийн нийт 53 камераас 30 камерт хяналт тавьж ажилласан. Нийт 30 камераас Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтсийн 19, 3 дугаар хэлтсийн 11 камер ажиллаж байна. Үүнээс нэгдүгээр хэлтсийн нутаг дэвсгэрт байрлах 26 камераас 7 камер, гуравдугаар хэлтсийн 27 камераас 16 камер ажиллахгүй байна.

Удирдах албан тушаалтны зөвшөөрлөөр нийт 33 удаа 16 цагийн бичлэг шүүж, 3 удаа гэмт хэргийг камерын бичлэгээр илрүүлэн холбогдох албан тушаалтнуудад

шилжүүлсэн. Мөн 1 зөрчлийг холбогдох албан хаагчид мэдэгдэж торгуулийн арга хэмжээ оногдуулсан.

Цагдаагийн байгууллагийн нэгдсэн санд хэсгийн байцаагчийн захиргааны үүргийн хүрээнд хариуцсан хорооны нутаг дэвсгэрийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын 25 мэдээ, мэдээллийг санд оруулах ажлыг зохион байгуулсан.

Захиргааны хяналтын 19 этгээдэд хяналт тавьж, сар бүрийн 15-ны дотор хэсгийн байцаагч нар биечлэн уулзаж, хууль зүйн зөвлөгөө өгч дахин гэмт хэрэг зөрчилд өртөж холбогдохгүй байх талаар баталгаа гаргуулан, дүүргийн хяналтын прокурорт хуваарийн дагуу материалыг хянуулан ажилласан.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам журам /код-707/-д заасан хөтлөгдвөл зохих бүртгэл судалгааг бүрэн шинэчилж нэг загварт оруулах ажлыг зохион байгуулж 1 удаа бичгээр зааварчилгаа өгч биелэлтийг тооцсон.

Иргэдээс ирүүлсэн гомдол мэдээлэл, зөрчлийн хэрэгт хийгдвэл зохих ажиллагааны талаар бичгээр нийт 56 хэрэгт зааварчилгаа өгч зөрчлийн хэргийг түргэн шуурхай хуулийн хугацаанд шийдвэрлэж иргэнд эргэж шийдвэрлэлтийн талаар хариу өгөх ажлыг бүрэн хэвшүүлсэн.

Тус хэлтсийн хариуцсан хорооны нутаг дэвсгэрт архи согтууруулах ундаагаар үйлчилдэг, худалдан борлуудаг 310 диско клуб, ресторан, кафе, караоке, хүнсний дэлгүүрүүдэд 15 офицер, 15 цагдаа, 4 олон нийтийн цагдаа, 15 станц, 6 автомашин болон хүн хүчтэйгээр архи согуутуурлах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжид хяналт тавь, цагийн хууварийн дагуу ажиллуулах болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилласан.

Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль” болон бусад хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоол, Засаг даргын захирамж, шийдвэрийг хангуулах чиглэлээр дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэстэй хамтарсан шалгалтыг 1 удаа зохион байгуулж, 150 аж ахуйн нэгж байгуулагад хяналт тавьж, зөрчилтэй 3 байгуулагад мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн мэдэгдэх хуудас өгч, 6 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг торгож ажилласан.

Тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байр нь Цагдаагийн нэг, хоёр, гурав дугаар хэлтэс болон Замын цагдаагийн хэлтсүүдээс зөрчил гарган ирсэн иргэдийг хүлээн авч хоногт 30-35 иргэнийг хүлээн авч ажиллаж байна. Тус байр нь 2019 оны эхний 3 сард 948 хүнийг хүлээн авч, хүний амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалж хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

Эрүүлжүүлэх саатуулах байранд ирсэн иргэдээс эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах шаардлагатай болсон нийт 540 хүнд эмнэлгийн анхны тусламж үзүүлсэн.

Саатуулах байр, жижүүр, авто эргүүлийн алба хаагчдыг цаг үеийн нөхцөл байдалд тохируулан хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт хүн хүчээ оновчтой зөв зохион байгуулах зорилгоор 6 цагаас илүүгүй цагаар явган эргүүлээр ажиллуулж, авто эргүүлийн алба хаагчдыг 12/12/48, 24/12, 24/48 цагаар хуваарьт оруулан ажиллуулж өдөр тутам тасгийн дарга, ахлах байцаагч нарын зүгээс тогтмол хяналт тавин ажилласан. Эргүүлийн үүрэг гүйцэтгэх үед нь алба хаагчдын албаны тусгай хэрэгсэл, хутганаас хамгаалах хантааз, агсамж зэргийг биедээ авч явж байгаад хяналт тавьж өмсөж хэвшүүлсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгүүдэд хулгай, дээрэм, булаалтын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн хүчний болон эмзэг цэгийн судалгааг гаргаж, тус хэлтсээс 2018 оны 12 дугаар сарын 26-ны

өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрүүдэд 10:00-14:00 цаг, 15:00-19:00 цагийн хооронд давхардсан тоогоор нийт 322 чиглэлд 1060 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэж, Зөрчлийн тухай хуулиар 1008 иргэнийг 77,945,500 төгрөгөөр торгож, 12877 сэжигтэй иргэн, 19068 тээврийн хэрэгсэл, 848 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж ажилласан.

Тус хэлтсээс тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн хүчний болон эмзэг цэгийн судалгааг гаргаж, “Ломбард”, “Сар шинэ-2019”, “Хэсгийн байцаагч”, “Зам, хяналт, шалгалт”, “Хяналт, шалгалт”, “Нийтийн байр”, “Хяналт, шалгалт-2019” зэрэг 8 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд явган болон авто эргүүлд 84 офицер, 164 ахлагч, 7 олон нийтийн цагдаа нарыг Эргүүл хамгаалалтын газрын 15 алба хаагч, Хууль сахиулахын их сургуулийн 14 сонсогчийн хамт 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрүүдэд явган эргүүлийн хуваарь, томилгоонд оруулан өдөр бүр 10:00-14:00, 15:00-19:00 цагийн хооронд давхардсан тоогоор нийт 130 чиглэлд 321 алба хаагч үүрэг гүйцэтгэснээр Зөрчлийн тухай хуулиар 644 иргэнийг 32,243,500 төгрөгөөр торгож, 815 сэжигтэй иргэн, 739 тээврийн хэрэгсэл, 449 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж, ар гэртээ болон гудамж талбай олон нийтийн газарт бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан болон танхайрсан 294 иргэнийг эрүүлжүүлж, 5 иргэнийг шүүхээр баривчлуулж ажилласан.

Олон нийтийн цагдаа нарыг хамт олонтой танилцуулах, найрсаг дулаан уур амьсгал бүрдүүлэн, алба хаагчдын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор Цагдаагийн хэлтсийн 2019 оны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд идэвх санаачлагчтай оролцсон. Хэлтсээс зохион байгуулсан 4 сургалтад оролцуулан, элэгний В.С вирусийн үзлэг шинжилгээнд харуулсан. Олон нийтийн цагдаагийн ажилтан нараас 2019 оны 1 дүгээр улиралд сахилга хариуцлагын зөрчил дутагдалгүй, ажлын цагийг баримтлан ажилласан. Сар бүр “Онцлох олон нийтийн цагдаа”-г шалгаруулж, хэлтсийн хүндэтгэлийн самбарт зургийг байрлуулсанаар олон нийтийн цагдаа нарын ажлын урам зоригийг нэмэгдүүлсэн.

Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрийн иргэдээс 2019 оны эхний 3 сард 15 галт зэвсэг бүртгэгдсэнээс хаяг шилжиж ирсэн 5, хаяг шилжиж явсан 1, бүртгэгдсэн хаяг дээр 6 галт зэвсэг тус тус бүртгэж, 50 галт зэвсгийг бүртгэл судалгаанд авч ажилласан. “Зэвсэг-2018” оны нөхөн тооллогын хүрээнд нийт 74 галт зэвсгээс 34 галт зэвсгийг тооллогод хамруулан ажилласан ба үлдэгдэл 30 галт зэвсгийн эрэн сурвалжлах ажиллагааг үргэлжлүүлэн хийж байна.

Хариуцсан нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын нэгдсэн мэдээллийн цахим сан болох SAS программд мэдээлэлээ шивж оруулах талаар мэдэгдэл өгч үр дүнг тооцон ажилласан. Мөн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа банк, банк бус санхүүгийн байгууллагын төв, салбаруудын объектын аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллаж байгаа, хамгаалагч нарын ур чадвар, үүрэг гүйцэтгэлт, албаны тусгай хэрэгсэл ашиглах, шуурхай албаны бүлгийн ирж буй цаг хугацаа зэрэгт хяналт тавьсан.

Тус хэлтсээс 2019 оны эхний 3 сарын байдлаар нийт 2 удаагийн хэв журмын хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг боловсруулан батлуулж ажилласан. Цагаан сар, Шинэ жилийн баяр, амралтын өдөр зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө, зураглалыг боловсруулан батлуулж, хамгаалалтыг давхардсан тоогоор 120 алба хаагч, ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулж мэдээг тухай бүр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн дахин сонгуулийн хамгаалалтад 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдрийг дуустал сонгуулийн санал авах 1812, 1813, 1814 дугаартай байруудад хэв журмын 18 алба хаагчийг, 3 ширхэг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагийг 3 алба хаагч, бэлэн байдалд 60 алба хаагч хамгаалалт ажилласан ба сонгуулийн үйл ажиллагаа ямар нгээн зөрчил дутагдалгүй болж өнгөрсөн талаар удирдах дээд байгууллагад танилцуулгыг хүргүүлсэн. Эх орончдын өдөрт зориулсан Хүчит бөхийн барилдаан Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо “Бөх”-ийн өргөөнд зохион байгуулагдах үеийн хамгаалалтанд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 10 алба хаагч 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 11:00-20:00 цагийн хооронд зөрчил дутагдалгүй ажиллаж, фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулан ажилласан.

Аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, шалгалтыг хэсгийн байцаагч, хороон цагдаа, машинт эргүүл, хэсэг кобаны алба хаагч нарын хамт тогтмол зохион байгуулж, гудамж талбай, олон нийтийн газар, харуул хамгаалалтгүй байрлуулж орхисон автомашинуудад гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, иргэд бүр сонор сэрэмжтэй байх талаар зөвлөмж 314, санамж 408, сэрэмжлүүлэг 716 хувийг хэвлүүлэн иргэдэд тарааж ажилласан.

Олон нийтийн цагдаагийн ажилтнууд хэсгийн байцаагч, хорооны цагдаатай хамтран давхардсан тоогоор 12 удаа хэргийн газрын хамгаалалтанд ажиллаж, 23 зөрчлийг таслан зогсоож, оршин суугаа газраасаа алга болсон гэх 14 иргэнийг эрэн сурвалжлах ажилд хамтран үүрэг гүйцэтгэсэн.

Хариуцсан нутаг дэвсгэрт гэрээт харуул хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 106 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, гэрээт харуул хамгаалалтын байгууллагуудын нэгдсэн мэдээллийн цахим сан болох SAS программд мэдээлэлээ шивж оруулах талаар мэдэгдэл өгч хамгаалагч нарын ур чадвар, үүрэг гүйцэтгэлт, албаны тусгай хэрэгсэл ашиглах, шуурхай албаны бүлгийн ирж буй цаг хугацаа зэрэгт хяналт тавин ажилласан.

“Эмчилгээ” хэсэгчилсэн арга хэмжээг 2019 оны 02 дугаар сард зохион байгуулж байнга архидан согтуурч орчиндоо түгшүүр төрүүлдэг, оршин суух хаяг тодорхойгүй, орон гэргүй тэнэмэл байдлаар амьдардаг архаг архичин 2 иргэнийг шүүхээр оруулж “Албадан эмчлэх төвд” хүргэн өгсөн.

Тус хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрт тэнэмэл байдлаар амьдардаг орон гэргүй 823 иргэнийг Улаанзагалмай, Энэрэл эмнэлэгтэй хамтран сүрьегийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулсан.

Хариуцсан нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн амьдрах орчны эрүүл аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр болон “Эмзэг цэг-хяналт шалгалт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 168 баар, 221 караоке, 81 саун массажны газар, 320 хүнсний дэлгүүр, 218 зочид буудал, 137 дэн буудал, 66 цахим тоглоомын газар, 705 түргэн үйлчилгээний цэгт давхардсан тоогоор хяналт тавьж, зөрчил гаргасан 18 иргэн, аж ахуй нэгж байгууллагыг шийтгэлийн хуудасаар 2500000 төгрөгөөр торгож ажилласан.

Тус хэлтсээс 2019 оны эхний 3 сарын байдлаар нийт 2 удаагийн хэв журмын хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг боловсруулан батлуулж ажилласан. Цагаан сар, Шинэ жилийн баяр, амралтын өдөр зохион байгуулагдах арга хэмжээний төлөвлөгөө, зураглалыг боловсруулан батлуулж, хамгаалалтыг давхардсан тоогоор 120 алба хаагч, ямар нэгэн зөрчил дутагдалгүй зохион байгуулж мэдээг тухай бүр Нийслэлийн цагдаагийн газарт хүргүүлсэн.

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн дахин сонгуулийн хамгаалалтад 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдрийг дуустал сонгуулийн санал авах 1812, 1813, 1814 дугаартай байруудад хэв журмын 18 алба хаагчийг, 3 ширхэг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагийг 3 алба хаагч, бэлэн байдалд 60 алба хаагч хамгаалалт ажилласан ба сонгуулийн үйл ажиллагаа ямар нгээн зөрчил дутагдалгүй болж өнгөрсөн талаар удирдах дээд байгууллагад танилцуулгыг хүргүүлсэн.

Эх орончдын өдөрт зориулсан Хүчит бөхийн барилдаан Баянзүрх дүүргийн 6 дугаар хороо “Бөх”-ийн өргөөнд зохион байгуулагдах үеийн хамгаалалтанд Нийтийн хэв журам хамгаалах тасгийн 10 алба хаагч 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 11:00-20:00 цагийн хооронд зөрчил дутагдалгүй ажиллаж, фото зураг, дүрс бичлэгээр баримтжуулан ажилласан.

Бүгд Найрамдах Солонгос ард улсын ерөнхий сайд Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын төлөвлөгөөний дагуу Хамгаалалтын салбар төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн нийт бие бүрэлдэхүүнд танилцуулан, хэлтсийн дарга болон Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нэгдсэн үүрэг чиглэл, зааварчилгаа өгч, алба хаагч нэг бүрээр гарын үсэг зуруулан хувцас форм, тусгай хэрэгсэл, гэрэл ойлгогчтой хантааз, агсамжинд үзлэг шалгалт хийж, алба хаагч бүрийн хувийн бэлтгэлийг хангуулан, хамгаалалтын үед үүсч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг баримтжуулах дүрс бичлэгийн камер, фото аппарат, нөөц батарей, хэргийн газрын хамгаалалтын тууз, олс бэлтгэн албаны бэлэн байдлыг хангаж, 70 алба хаагч ажилласан.

2.2 Урьдчилан сэргийлэх чиглэлээр

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан “Хөршийн хяналт хөтөлбөр” журмыг иргэд олон нийтэд сурталчилан таниулах, иргэд оршин суугчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэх, амьдарч буй орчинд нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулж эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор тус хэлтсийн хариуцсан хороодын нутаг дэвсгэрт хөршийн хяналтын 17 бүлэг ажилласан. Тайлангийн хугацаанд урамшилт эргүүлүүдээс 7 хоногт 1 удаа, өдөрт 2 цагийн хугацаатайгаар гэмт хэрэг гарч болзошгүй эмзэг цэгт эргүүл хийж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байж болзошгүй 1, гэртээ бүлэг бөөгнөрөл үүсгэн байнга архидан согтуурч орчин тойрныхоо амгалан тайван байдлыг алдуулдаг 2, нийт 3 зөрчлийн мэдээллийг хэсгийн байцаагч, хороо хариуцсан цагдаа нарт мэдээлэл өгч, хяналтанд авхуулсан. Хариуцсан нутаг дэвсгэрт ажиллаж байгаа нийт 17 хөршийн хяналтын бүлгийн 64 гишүүдийн тусламжтайгаар тухайн Хөршийн хяналтын бүлгэмийн харъяалах нутаг дэвсгэрт байдаг хараа хяналтгүй хонуулдаг автомашины эздүүдэд эд зүйлээ хулгайд алдахаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж болон 330 ширхэг тараах материал өгч ажилласан.

Тус хэлтсээс хорооны Засаг дарга, хэсгийн байцаагч, хороо хариуцсан мөрдөгч, цагдаа нийт 32 хүн хамрагдсан. Уулзалтаар камергүй аж ахуй нэгж, байгууллагыг камержуулж камерын хяналтыг сайжруулах, стандартад нийцээгүй камерыг стандартад зааснаар шинэчлэх, хороодын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн.

Хариуцсан хорооны нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 иргэн урамшилт эргүүлээр үүрэг гүйцэтгэж, хугацаандаа 16 санамж, сэрэмжлүүлэг

тарааж, цагдаагийн 102 тусгай утсанд дуудлага 2 удаа өгч, олон нийтийн газар танхайрч байсан 2 иргэнийг машинт эргүүлийн алба хаагч нарт хүлээлгэн өгч ажилласан. Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн “School police”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажилласан.

Хороо хариуцсан хэсгийн байцаагч нарт 2019 оны 02 сард хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй болон хорих газраас суллагдсан хүмүүст хяналт тавьж ажиллахад анхаарах асуудлын талаар зааварчилга бичиж, үр дүнг тооцон ажилласан. Хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй иргэдийн болон хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд захиргааны хяналт тавих, хувийн хэргийн баяжилт хийх зэрэгт зөрчил гаргуулахгүй байхад анхаарч 2019 оны 01 дүгээр сард захиргааны хяналтын хувийн хэрэг нэг бүр дээр тулгалт хийж ажилласан. Хяналтанд байгаа 15 иргэнтэй болон ар гэрийн гишүүдтэй 2019 оны 01 дүгээр сард уулзалт зохион байгуул, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн яриа таниулга хийсэн.

Тус хэлтсээс 2019 оны аж ахуйн нэгж, байгууллага болон иргэдэд гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулахаар мөрдөгч нараас нийт 107 албан мэдэгдэл өгч, 70 хариу, хэсгийн байцаагч нараас шаардлага өгч, 790 хариуг авч, 680 шаардлагын биелэлтийг газар дээр нь үзэж, үр дүнг нь тооцож ажилласан.

Нийт 36 мэдэгдлийн хариуг хуулийн хугацаанд авч, хариу хүргүүлсэн аж ахуй нэгж байгууллагын мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлыг шалгах хүрээнд нийт 8 мэдэгдлийг хариуг шалгаж ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээний талаар телевиз, радио, өдөр тутмын сонинд 9 мэдээ, мэдээлэл, 7 удаа ярилцлага өгч, 1 удаа нэвтрүүлэгт оролцсон. Мөн тус цагдаагийн хэлтсийн хэлтсийн “*bayanzurkh-1.police.gov.mn*” цахим, “Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтэс” нэртэй фейсбүүкийн пэйж хуудсанд хэлтсийн үйл ажиллагааны нийт 58 мэдээллийг байршуулан ажилласан.

2.3 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр

Гэр бүлийн хүчирхийллээр 2 буюу түүнээс дээш Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага өгсөн 143 иргэдийнболон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж 3 ба түүнээс дээш баривчлагдсан 43 иргэдийн судалгааг гаргаж хяналт тавьж ажилласан. Хорооныхоо Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг хяналтанд авах зорилгоор хороо бүр дээр гэр бүлийн хүчирхийллийн дуудлагаар ирсэн мэдээллийг бүртгэлд авч, дуудлага өгөхөд гэрээсээ гарч зугтаасан иргэдийг олж материалжуулан арга хэмжээ тооцож байна. Тус хэлтсийн саатуулах байранд хоногийн хугацаанд саатуулагдсан 37 иргэнд Гэр бүлийн хүчирхийлэл, 1 ХОРОМ-ын талаар шторк үзүүлж, сургалт мэдээлэл хийж, 250 иргэдэд ухуулга яриаг зохион байгуулсан. Мөн хэлтсийн хариуцлагатай эргүүл гхоногийн хугацаанд 2-оос доошгүй гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэлд очиж ажиллан алба хаагчдад зөвлөгөө өгч ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрийн ерөнхий боловсролын 9 сургуулийн эцэг эхийн “School Police” эргүүлийг ажиллуулж, 8 сургуулийн эцэг эхэд хэрхэн ажиллах болон эргүүлийн ач холбогдлын талаар зааварчилгаа өгч ажилласан. Дэлхийн зөнтэй ОУ-ын байгууллагатай хамтран “Гэр бүлийн баяр хөөр” сургалтанд хэлтсийн 57 алба хаагч, гэр бүлийн гиүүний хамт сургалтанд хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр, цахим тоглоомын хор уршиг болон гэр бүлийн хүчирхийлэл гэж юу түүнээс өөрийгөө болон бусдыг хамгаалах нь сэдвээр 1470 сурагчидтай хэлэлцүүлэг яриа хийж, “Өсвөрийн сэргийлэгч хүү” хүүхэлдэйн кино үзүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гар утас, үнэт эд зүйл хэрэглэхгүй байх талаар сурталчлахаар сургалтын хуваарь гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хариуцсан хороодын 8 сургуульд хэсгийн байцаагч нарын хамт сургалт зохион байгуулан ажилласан. Энэ чиглэлээр 3 төрлийн зурагт хуудас 200 ширхэг, санамж, сэрэмжлүүлэг 80 ширхэгийг тараасан.

Орон гэргүй тэнэмэл иргэд, хүүхдүүдийг Улаан загайлмайн нийгэмлэгтэй хамтран эмнэлгийн анхны тусламж үзүүлж, хүүхэд хамгааллын 108-д 9 хүүхдийг хүлээлгэн өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 1 цагийн мэдээллийг өгсөн.

Хариуцсан нутаг дэвсгэрт хараа хяналтгүй хүүхдүүдийг илрүүлэх зорилгоор 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс мөн оны 3 сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд “Илрүүлэлт-2019” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, хараа хяналтгүй 18 хүүхдээс 9 хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 9 хүүхдийг түр хамгаалах байранд хүлээлгэн өгч ажилласан. Мөн “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан нутаг дэвсгэрээр тэнэдэг орон гэргүй 56 иргэнийг илрүүлж, цагдаагийн асап санд шивж, гарын хээг авч бүртгэлжүүлсэн.

Тус хэлтэст 2019 оны эхний 2 сарын байдлаар хүүхэд оролцсон гэмт хэрэг 2 бүртгэгдсэн ба 1 нэгжээр 33,3 хувиар буурсан.

2.4. Гэмт хэрэгтэй тэмцэх ажлын талаар

Тус хэлтэст 2019 оны эхний 2 сарын байдлаар иргэд аж ахуй нэгж, байгууллагаас ирүүлсэн нийт 1379 гомдол, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсний 538 буюу 39.0 хувь нь гэмт хэргийн, 841 буюу 60.9 хувь нь захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хэлтсийн нэгдсэн бүртгэлд бүртгэн, санд баяжилт хийн, хяналт тавьж ажилласан.

Гэмт хэргийн шинжтэй 538 гомдол, мэдээллийн 220 буюу 40.8 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, 264 буюу 49.0 хувийг нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтайгаар прокурорт хүргүүлж, 7 буюу 1.3 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн. Зөрчлийн шинжтэй 841 гомдол, мэдээллийн 237 буюу 28,1 хувийг зөрчлийн хэрэг нээсэн, 568 буюу 67,5 хувийг зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 2 буюу 0,2 хувийг харъяаллын дагуу шилжүүлсэн.

2019 оны эхний 2 сард 354 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 202 нэгжээр буюу 36,3 хувиар буурсан. Хэрэг бүртгэлтийн хэрэг 343 хэрэг бүртгэгдсэн, үүнээс 41 хэргийн яллагдагчаар татаж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Нийт хэргийн илрүүлэлт 12,0 хувьтай, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6,0 пунктээр өссөн. Хөнгөн хэргийн илрүүлэлт 12,8 хувьтай, 7,2 пунктээр өссөн, хүнд хэргийн илрүүлэлт 8,1 хувьтай, 0,2 пунктээр буурсан,

Гудамж талбайд 66 хэрэг бүртгэгдэж 66 нэгжээр буюу 50 хувиар буурсан. Согтуугаар үйлдэгдсэн хэрэг 6 бүртгэгдэж 2 нэгжээр буюу 50 хувиар өссөн.

Тайлангийн хугацаанд нууц далд аргаар үйлдэгдсэн гэмт хэргийн талаар мэдээ, мэдээлэл цуглуулан 318 холбогдогчтой, 17,969,4 мянган төгрөгийн хохиролтой 270 гэмт хэрэг, үйлдэл илрүүлэн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах алба болон бусад газар хэлтсүүдэд шилжүүлсэн байна.

Алба хаагчдаас ЦБҮАЖ-ын код 307-д заасан "Илтгэх хуудас"-аар 116 мэдээ, мэдээлэл дэд санд авагдсанаас 17 мэдээллийг засуулахаар буцааж, 99 мэдээллийг эрүүгийн мөрдөгч нарт хуваарьлан шалгуулснаас 21 мэдээлэл батлагдсан, 38 мэдээ, мэдээлэл батлагдаагүй, 40 мэдээллийг шалгаж байна.

Тус хэлтэст шалгасан хэргийн улмаас 2480 иргэн, аж ахуй нэгж, байгууллагад 12,595,7 сая төгрөгийн хохирол учирснаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын

шатанд 1,796,6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, шүүхээс эд хөрөнгө хураах, иргэний нэхэмжлэлийг хангах зорилгоор холбогдчон этгээдийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан болон хувьд ногдох 367,0 сая төгрөгийн эд хөрөнгийг битүүмжилсэн. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 1224,6 сая төгрөгийн хохирол учирснаас 43,1 сая төгрөг буюу 3,5 хувийг нөхөн төлүүлжээ.

Алба хаагчдаас 2019 оны нэгдүгээр улиралд прокурорын шаардлага ирээгүй.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах АСАП санд эрэн сурвалжлагдаж байсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 26 зарлагдсанаас 6, 2 оргодол этгээдээс 2, эрэн сурвалжагдаж байсан эд зүйл 22 зарлагдсанаас 5 олж тогтоон шийдвэрлэж, сангийн зөрчлийг арилгах хасалт хийлгэх талаар ЭЦА-ны 7 дугаар хэлтэст танилцуулгыг хүргүүлэн ажилласан.

Тус хэлтсээс 2019 оны эхний 3 сарын байдлаар эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах чиглэлээр 5 нэгдсэн болон хэсэгчилэн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцоход хариуцсан нутаг дэвсгэрт байрладаг баар, караоке 14, нийтийн байр 26 шалгаж, хэрэгт шалгагдаж байгаад мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан 1, гэмт хэрэг сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байгаа 2 этгээдийг баривчилж хариуцсан алба хаагчид шилжүүлсэн. Мөн Дүүрэн инвест ХХК, Фелиз монголиа ХХК, Ажнай соёолон ХХК, Буянт үенч ХХК, ММ Эко сити ХХК, Энх жагар ХХК, Төгс сод билэгт ХХК-ны удирдлагуудтай хамтран байгууллагын орчинд нийт 60 камерын хяналтыг шинээр суурьлуулсан. Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 автобусны буудлууд, ТҮЦ-дэд чанга яригч байрлуулан, Нарантуул ОУХТ, Баялаг ундраа захын чанга яригчаар 30 минутын давтамжтайгаар иргэдэд халаасны хулгайгаас сэргийлэх талаар сэрэмжлүүлэг текстийг уншуулсан. “Эх орон” телевизээр арга хэмжээний хүрээнд алба хаагчдаас илрүүлсэн гэмт хэргийн талаар мэдээллийг 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн эфирээр хүргэж ажилласан. Иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг 30, дүүргийн иргэд нэгдсэн групп /13941 хандагчтай/, Баянзүрх дүүргийн групп /13163 хандагчтай/, Баянзүрх дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэс /2200 хандагчтай/, 24 цаг мн, шуурхай.мн, news.mn, нийгмийн толь, онцлох.мн, Цагдаагийн алба хаагчдын эрх ашгийг хамгаалах холбоо /19257 хандагчтай/, Police Mongolia /7695 хандагчтай/ FACEBOOK группүүдэд мэдээллийг байршуулан ажилласан. Томоохон зах, худалдааны төвүүд, олон нийтийн газар болон өдөрлөгийн үеэр архины хор уршгийг суртачилсан гарын авлага 100 ширхэг, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх утга бүхий зурагт хуудас 4 төрлийн 430 ширхэг, сэрэмжлүүлэг зөвлөмж 150 ширхэг, автомашиндаа эд зүйлээ орхихгүй байх талаар санамж 136 ширхэг, нийт 816 ширхэгийг тараасан.

“Зам-Хяналт, шалгалт” арга хэмжээг 2,3 дугаар хэлтэс болон Эргүүл хамгаалалтын газартай хамтран зохион байгуулж, хариуцсан нутаг дэвсгэрийн хоногийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгдсэн болон үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийг эргүүлийн хяналтад авах, хүн хүчний болон эмзэг цэгийн судалгааг гаргаж, явган болон авто эргүүлд нийт 84 офицер, 164 ахлагч, 7 олон нийтийн цагдаа нарыг хуваарь, томилгоонд оруулан, өдөр бүр 08:00 цагаас 12:00 цаг 14:00 цагаас 18:00 цагийн хооронд 230 чиглэлд 478 алба хаагчийг эргүүлээр хяналт тавиулан ажиллаж, Зөрчлийн тухай хуулиар 123 иргэнийг 9,690,000 төгрөгөөр торгож, 815 сэжигтэй иргэн, 739 тээврийн хэрэгсэл, 384 аж ахуй нэгж байгууллагыг шалгаж, ар гэртээ болон гудамж талбай олон нийтийн газарт согтуугаар танхайрсан 31 иргэнийг тус хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байранд хүлээлгэн өгсөн. Эргүүлийн чиглэл дээр 1 гэмт хэрэг, 1 гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг илрүүлсэн. Мөн бэлэн мөнгө ихээр төвлөрдөг банк, банк бус санхүүгийн байгууллага, валют арилжааны цэг, барьцаалан зээлдүүлэх газар, тэсэрч дэлбэрэх, шатах тослох материал худалдан борлуулдаг цэг, томоохон

худалдааны төв зэрэг газруудад баяр, амралтын өдрүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлаа хангаж ажиллах талаар 87 аж ахуй нэгж байгууллагад шаардлага өгч, үр дүнг тооцож, 964 санамж, сэрэмжүүлэг тарааж ажилласан.

Халаасны хулгайн 15 зөрчлийн хэргийг хаах саналтай шийдвэрлэн, халаасны хулгайн зөрчил гаргасан 3 этгээдийг шүүхээр 7-30 хоногоор баривчлуулах шийтгэл оногдуулсан. Эрүүгийн цагдаагийн тасагт шалгагдаж байгаа эзэнгүй хэргүүдийг илрүүлэх, шийдвэрлэх график төлөвлөгөөг 7 хоног бүрээр гаргаж халаасны хулгайн 56 хэргийг хааж шийдвэрлэсэн. Халаасны хулгайн гэмт хэрэг үйлдэн эрэн сурвалжлагдаж байсан 1 этгээдийг тогтоон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч, мөрдөн байцаах тасагт шилжүүлсэн. Мөн халаасны хулгайн гэмт үйлдэж болзошгүй 30 этгээдийг судалгаанд авч, зөрчлийн 5 хэрэг, хэрэг бүртгэлтийн 1 гэмт хэргийг, зөрчлийн 7 хэрэг илрүүлж, 2 этгээдийг баривчилж ажилласан.

Мөрдөн байцаалтын чиглэлээр: Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн гэмт хэргийн шинжтэй 248, мэдээлэл хүлээн авч шалгаж 94 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 131 гомдол мэдээлэлд хэрэг нээхээс татгалзах саналтай прокурорт шилжүүлсэн ба харъяаллын дагуу 11 гомдол, мэдээлэл шилжүүлж 12 гомдол мэдээлэл хуулийн хугацаанд шалгагдаж байна.

Нийт 293 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 128 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай, 48 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай тус тус прокурорт шилжүүлж, 33 хэргийг өөр хэрэгт нэгтгэн нийт 209 хэргийг шийдвэрлэсэн байна. Харъяаллын дагуу бусад газар хэлтэст 55 хэрэг шилжүүлсэн болно. Одоо мөрдөн байцаалтын 29 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна. Үлдэгдэл хэргээс хугацаа хэтрэн шалгагдаж байгаа буюу 1-3 дугаар хугацаанд шалгагдаж байгаа 3 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

Нийт 780 хэрэгт хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 217 хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, 203 хэрэг бүртгэлийн хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, харъяаллын дагуу бусад газар, хэлтэст 27 хэрэг шилжүүлж, одоо 333 хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд нийт 31 яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас, одоо 5 яллагдагч хоригдон шалгагдаж байгаагаас 1 сараас дээш хугацаагаар цагдан хоригдож байгаа яллагдагч 2 байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч нараас гаргасан 6 хүсэлтийг хүлээн авч, шалган 4 хүсэлтийг хангаж, 2 хүсэлтийг хангахаас татгалзаж одоо хүсэлтийн үлдэгдэлгүй байна.

Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт шилжүүлсэн 128 хэрэгт мөрдөгчийн мэдэгдэл бичиж холбогдох газруудад нь хүргүүлж хариуг авч ажилласан болно.

Тасгийн эд мөрийн баримт хадгалах өрөөнд хадгалагдаж байгаа эд мөрийн баримтуудыг нэг бүрчлэн тоолж эрүүгийн хэрэгтэй нь тулгалт хийж ажиллагаанд шалгагдаж байгаа хэргийн эд мөрийн баримтуудыг зохих журмын дагуу хадгалж байна.

Мөрдөн байцаах тасгийн хэмжээнд хугацаа сунгасан, шүүх, прокуророос буцсан, ялангуяа удааширч байгаа шийдвэрлэгдэхгүй хэргүүдийг Дүүргийн прокурорын газрын орлогч болон ахлах прокуроруудад танилцуулан хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхэд анхаарч даргын даалгавар бичиж зааварчлах, ахлах мөрдөгч, мөрдөгчийн ажлын хэсэг томилж удирдлага зохион байгуулалтаар ханган ажилласнаар тус тасаг нь ажлын үзүүлэлтээрээ албаны хэмжээнд 1, 2 дугаар сард ажлаараа тэргүүлсэн. Мөн 1 мөрдөгч 80-90 хэрэг гар дээрээ шалгаж байсан бол 45-50 хэрэг болж ажлын ачаалал 25-30 хувь

буурсан. Удаашран шалгаж байсан 17 хэрэг байснаас 15 хэргийг шийдвэрлэж, 2 хэргийн үлдэгдэлтэй байна.

Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргуулахгүй байх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор “Мөрдөгч нарт өгсөн өдөр тутмын зааварчилга, зөвлөмжийн дэвтэр”-ийг шинээр хийж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. Хэлтсийн даргын явцын хяналтанд орсон гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн шалгалтын явц байдлыг тогтоосон хугацаанд нь мөрдөгч нарын хамт эргэж танилцуулж хэвшлээ. Тасгийн даргаас энэ сард 28 гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийн шалгалтын явц байдлыг хяналтандаа авч 7 хоногт тутам танилцан үүрэг чиглэл, арга зүйн зөвлөгөө өгч ажилласнаар гомдол мэдээлэл, эрүүгийн хэрэг шийдвэрлэгдэж буй хугацаа багасч, иргэдээс алба хаагчдын үйл ажиллагаанд холбогдуулан гомдол гаргаагүй зэрэг эерэг үр дүн гарч байна.

Хэрэг бүртгэлтийн чиглэлээр: 2019 оны 01 дүгээр улиралд иргэд аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 139 гомдол, мэдээллийг хүлээн авснаас гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналтай 57 буюу хувь 41 хувийг, гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээх саналтай 66 буюу 47.4 хувийг Баянзүрх дүүргийн прокурорын газарт хүргүүлж, 5 гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, үлдэгдэл 11 гомдол, мэдээлэлд шалгах ажиллагаа явуулж байна.

Тайлангийн хугацаанд нийт 412 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсны 109 хэрэг нь зөрчлөөс хэрэг бүртгэлтийн хэрэг нээн ирүүлсэн байна. Тайлангийн хугацаанд 106 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 44 хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, 122 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай дүүргийн прокурорт хүргүүлж, 4 хэргийг харъяаллын дагуу бусад газар шилжүүлж, тасагт үлдэгдэл 225 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд шүүхээс буцсан хэрэггүй, прокурорын байгууллагаас хаах саналтай хүргүүлсэн 1, нэмэлт ажиллагаанд 15 хэргийг буцаасныг хүлээн авч мөрдөн шалгаж ажиллагааг явуулж шийдвэрлэсэн. Иргэд аж ахуйн нэгжид гэмт хэрэг зөрчлөөс урьдчлан сэргийлэх чиглэлээр мөрдөгчийн мэдэгдэл 9-ыг бичиж, санамж сэрэмжлүүлэг нийт 113 ширхэгийг иргэн аж ахуйн нэгжид тараан өгч ажилласан. Хэрэг бүртгэх тасгийн даргын зүгээр нийт 89 хэргийг уншиж танилцан 17 хэрэгт бичгээр зааварчлага өгч 9 зааварчлагын хариуг хугацаанд нь авч биелэлтээ тооцон ажиллаж байна. Тайлангийн хугацаанд иргэд аж ахуйн нэгжид учирсан 56430000 төгрөгний хохирлоос 54920000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь 91.2 хувьтай байна.

Долоо. Дүгнэлт

Тайлант хугацаанд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлээр 5 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг 168 баар, 221 караоке, 81 саун массажны газар, 320 хүнсний дэлгүүр, 218 зочид буудал, 137 дэн буудал, 66 цахим тоглоомын газар, 705 түргэн үйлчилгээний цэгт давхардсан тоогоор хяналт тавьж, зөрчил гаргасан 18 иргэн, аж ахуй нэгж байгууллагыг шийтгэлийн хуудасаар 2,500,000 төгрөгөөр торгож ажилласан ба 62 удаа сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулж, 2 удаагийн өдөрлөг зохион байгуулж, 3076 иргэнийг хамруулж ажилласнаар гудамж талбайд 66 хэрэг бүртгэгдэж 66 нэгжээр буюу 50 хувиар буурсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Тэргүүн дэд дарга, Дэд дарга, Нийслэлийн цагдаагийн газрын дарга нарын өгсөн үүрэг, ажлын чиглэл, зөвлөмж, албан даалгаврын заалт бүрийн ард уг ажлыг хариуцан хэрэгжүүлэх

албан тушаалтны нэр, цолыг бичиж, нэгдсэн байдлаар биелэлт үр дүнг нь тооцох албан тушаалтанд цохолт хийж эзэнжүүлэн, үр дүнг нь тооцож ажилласан.

Энэ онд сард бие бүрэлдэхүүний дундын сангаас алба хаагчдын нийгмийн асуудал, соён гэгээрүүлэх ажилд нийт 2,144,000 төгрөгийг тус тус зарцуулсан. Тасаг албад сар бүр хамт олны хурлыг зохион байгуулж, алба хаагчдынхаа ажлын үр дүнг хэлэлцэн дүгнэж, ажлын байрны зорилго зорилт, үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн давхардсан тоогоор 61 алба хаагчийн албан тушаалын цалинг 5-25 хувь нэмж, 42 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувь бууруулж олгосон.

Мөрдөн байцаах тасгийн хэмжээнд хугацаа сунгасан, шүүх, прокуророос буцсан, ялангуяа удааширч байгаа шийдвэрлэгдээгүй хэргүүдийг Дүүргийн прокурорын газрын орлогч болон ахлах прокуроруудад танилцуулан хуулийн дагуу шуурхай шийдвэрлэхэд анхаарч даргын даалгавар бичин зааварчлах, ахлах мөрдөгч, мөрдөгчийн ажлын хэсэг томилж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласнаар тус тасаг нь ажлын үзүүлэлтээрээ Мөрдөн байцаах албаны хэмжээнд 2019 оны 1, 2 дугаар сард ажлаараа тэргүүлсэн. Мөн алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хуулийг нэг мөр хэрэглэх байдлыг сайжруулах зорилгоор Баянзүрх дүүргийн Прокурорын газартай хамтран хэргийн тооллого хийж, эрүүгийн хэрэг, гомдол мэдээллийн хяналтын бүртгэлийг MS Excel программ дээр шинэчлэн хийж, алба хаагч нэг бүрээр тулгалт хийж үлдэгдэл хэргийн тоо, ажлын ачаалал зэргийг гарган энэхүү тооцоо судалгаан дээрээ үндэслэн хэргийн шийдвэрлэлтийг ахиулах, ажлын ачааллыг бууруулах зорилго тавин ажилласнаар 1 мөрдөгч 80-90 хэрэг гар дээрээ шалгаж байсан бол 45-50 хэрэг болж ажлын ачаалал 25-30 хувь буурсан. Удаашран шалгаж байсан 17 хэрэг байснаас 15 хэргийг шийдвэрлэж, 2 хэргийн үлдэгдэлтэй байна.

Найм. Цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ

1. Баянзүрх дүүргийн Прокурорын газартай хамтран зөрчлийн тооллого хийж, зөрчлийн хэрэг, гомдол мэдээллийн хяналтын бүртгэлийг MS Excel программ дээр шинэчлэн хийж, алба хаагч нэг бүрээр тулгалт хийж үлдэгдэл хэргийн тоо, ажлын ачаалал зэргийг гарган энэхүү тооцоо судалгааг гарган цаашид хийх ажлаа тодорхойлох.

2. Нийслэлийн цагдаагийн газраас 2019 оныг “Ахлах ажилтны манлайллын жил” болго нзарласантай холбогдуулан ахлах албан тушаалтнуудын манлайлал, үүрэг оролцоог дээшлүүлэх.

3. Иргэдэд хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг нээлттэй хүргэж, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

ТАНИЛЦСАН:

ДАРГА,

ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Б.АРИУНЖАРГАЛ

ХЯНАСАН:

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ТАСГИЙН ДАРГА,

ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

Ц.ЛХАГВАСҮРЭН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ

МЭРГЭЖИЛТЭН, ЦАГДААГИЙН АХМАД

Г.БУЙРЦЭНГЭ